

Үнэ шилжилтийн тайлагналын

хуулийн хэрэгжилт

2023 оны Үнэ шилжилт ("ҮШ")-ийн тайланг тушаах хугацаа ойртож байна. Монгол Улсын ҮШ-ийн журмын дагуу татвар төлөгчид харилцан хамааралтай этгээдүүдтэй гүйцэтгэсэн хил дамнасан болон дотоодын ажил гүйлгээг аль алийг нь тайлагнах үүрэгтэй.

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Лхачингийн Аззаяа

Менежер
Үнэ Шилжилтийн үйлчилгээ
azzaya.lkhachin@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс
Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар хот
14200, Монгол улс
Утас: + 976 70009089
Факс: +976 11 322068
www.pwc.com/mn





ҮШ-ийн тайлантай холбоотой шаардлагууд

Татвар төлөгчид харилцан хамааралтай этгээдтэй гүйцэтгэсэн ажил гүйлгээний үнийг тогтоохдоо үнэ шилжилтийн дүрмийг баримтлан дараах үнэ шилжилтийн тайлангуудыг бэлтгэж, татварын албанд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

ҮШ-ийн тайлангийн ангилал	Тайланг хэн бэлтгэх вэ?	Хэзээ тушаах вэ?	Практикт анхаарах зүйлс
ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан	<ul style="list-style-type: none">Бүх татвар төлөгчид, харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний дүнгээс үл хамааран.	Дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор	<ul style="list-style-type: none">Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн бүх ажил гүйлгээг мэдээлэх;Хувьцаа эзэмшигчид болон харилцан хамааралтай талуудын талаарх мэдээллийг тайлагнах;Санхүүгийн ажил гүйлгээ, биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээг тусгайлан тайлагнах.
Дотоод ҮШ-ийн тайлан	<ul style="list-style-type: none">Өмнөх татварын жилд 6 тэрбум төгрөг (ойролцоогоор 1.7 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон аж ахуйн нэгж эсхүл групп компани;Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж (орлогын дүнгээс үл хамааран).		<ul style="list-style-type: none">Группийн түвшинд бэлтгэсэн глобал үнэ шилжилтийн баримтжуулалтад тайлагнах мэдээлэл, үнэ шилжилтийн аргачлалыг хэрэглэх гол шалгуур нь Монгол Улсын ҮШ-ийн журамд зааснаас ялгаатай бол глобал үнэ шилжилтийн баримтжуулалтыг Монгол улсын ҮШ-ийн журамд нийцүүлэн тайлагнах.
Ерөнхий ҮШ-ийн тайлан	<ul style="list-style-type: none">Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөг (ойролцоогоор 485 сая ам.доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлоготой Үндэстэн дамнасан групп ("ҮДГ") - ийн Монгол улсад байрладаг толгой компани эсхүл бусад томилогдсон этгээд.		Группийн санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын дотор

Энэхүү мэдээллийг ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

ҮШ-ийн ойлголт	Тайлбар
<p>ҮШ-ийн тайлангай холбоотой шаардлагууд</p>	<p>ҮШ-ийн тайланд тусгагдах мэдээлэл нь Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/133 дугаар тушаалаар баталсан ҮШ-ийн тайлангийн маягтын дагуу байх.</p> <p>Тухайлбал, хэрэв Монгол улсын ҮШ-ийн тайланд тайлагнах шаардлагатай мэдээлэл нь ҮДГ-ийн Ерөнхий үнэ шилжилтийн тайлан-д тусгагдаагүй бол тухайн мэдээллийг татвар төлөгч нь Монгол улсын ҮШ-ийн тайлангийн зорилгоор заавал тусгах шаардлагатай.</p> <p>Татвар төлөгч нь Дотоод үнэ шилжилтийн тайлан-д доорх үзүүлэлтүүдээс хамгийн их дүнтэй гэж тодорхойлогдсон харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд хийгдсэн ач холбогдол бүхий ажил гүйлгээнүүдэд хэрэглэсэн үнэ шилжилтийн бодлого, сунгасан гарын зарчмын шинж чанарыг үнэлж, тайлагнах үүрэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн нийт борлуулалтын орлогын 1%; ➢ Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1%; ➢ Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн дотоод эх үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгийн нэмж төлөгдсөн капиталын 1%; ➢ 50 сая төгрөгтэй тэнцүү буюу түүнээс дээших. <p>Дээрх шалгуурыг үл харгалзан бүх төрлийн санхүүгийн ажил гүйлгээ, биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээг ач холбогдол бүхий ажил гүйлгээ гэж үзэж Дотоод үнэ шилжилтийн тайлан-д тусгана .</p> 
<p>ҮШ-ийн тохируулга</p> 	<p>Хэрэв татвар төлөгч нь ҮШ-ийн тайланг гаргаагүй, эсхүл татварын ногдлоо дутуу тодорхойлж тайлагнасан бол татварын алба ҮШ-ийн үндсэн тохируулгыг хийж татварыг нөхөн ногдуулна. Түүнчлэн, татварын алба нь үндсэн тохируулгын үр дүнд үүссэн зөрүүг ногдол ашиг гэж үзэж татвар ногдуулах ба үүнийг хоёрдогч тохируулга гэнэ.</p> <p>Татвар төлөгч нь ҮШ-ийн бодлого болон ҮШ-ийн дүрэм журмыг дагаж мөрдөхөд өөрийн санаачилгаар жилийн эцсийн үнэ шилжилтийн тохируулгыг хийж гүйцэтгэж болно. Оновчтой ҮШ-ийн бодлого нь компанийн татварын сайн засаглалын чухал хэсэг бөгөөд үр ашигтай санхүүгийн үйл ажиллагааны гол шийдэл юм.</p> <p>Татвар төлөгчдийн зүгээс жилийн эцсийн ҮШ-ийн тохируулгыг өөрийн санаачилгаар хэрхэн тайлагнах талаарх асуултуудын хариултыг Монголын татварын албаны www.mta.mn цахим хуудасны “Үнэ шилжилтийн талаарх түгээмэл асуулт” хэсгээс дэлгэрэнгүй танилцаж болно.</p>
<p>ҮШ-ийн тайлангуудыг тушаагаагүй тохиолдолд хүлээх хариуцлага</p>	<p>ҮШ-ийн тайлангуудыг хугацаанд нь гаргаж, татварын албанд тушаагаагүй тохиолдолд дараах торгуулийг ногдуулахаар хуульд заасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 2 хувь; • Дотоод болон Ерөнхий үнэ шилжилтийн тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 3 хувь; • Улс бүрээр ҮШ-ийн тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 4 хувь.
<p>ҮШ-тэй холбоотой татварын маргаан</p>	<p>Татвар төлөгчдийн хувьд хэрэгжүүлж буй ҮШ-ийн бодлого нь сунгасан гарын зарчимтай нийцэж, эрхэлж буй бизнес болон үйл ажиллагааны мөн чанарыг тусгасныг харуулах нь чухал юм.</p> <p>Сүүлийн жилүүдэд татварын албанаас хийсэн ҮШ-ийн хяналт шалгалтын тоо, хэмжээ эрс нэмэгдсэн. Энэ талаарх мэдээллийг бид удахгүй хүргэх болно.</p>



PwC танд хэрхэн туслах вэ?

PwC-ийн дэлхийг хамарсан ҮШ-ийн үйлчилгээний тусламжтайгаар бид танд ҮШ-ийн тайлагнал, хуулийг дагаж мөрдөхийн тулд дэмжлэг үзүүлэх, стратегийн талаар зөвлөгөө өгөхөд бэлэн байна.



ҮШ-ийн эрсдэлийг тодорхойлох, ҮШ-ийн бодлого, журам боловсруулах



Групп доторх ажил гүйлгээний үнийн бодлого боловсруулалт, хөгжүүлэлт



ҮШ-ийн хэрэгжилтийг бүрэн гүйцэтгэх ҮШ-ийн бодлогын шийдэл



ҮШ-ийн дотоод хяналтыг бий болгоход үзүүлэх дэмжлэг



Бүх төрлийн ажил гүйлгээний ҮШ-ийн баримтжуулалт, тайланг дотоод хууль тогтоомжийн дагуу бэлтгэх, шинэчлэх



ҮШ-ийн хяналт шалгалтын явцад тусламж, дэмжлэг үзүүлэх



Энэхүү мэдээллийг ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-ийг илэрхийлнэ.